



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/129

Бат-Өлзий сум

Хорио цээр тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын ой бүхий 7407 га талбайд “Гранд Форест” хязгаарлагдмал хариуцлагатай компани ойн хортон шавж устгалын ажлыг гүйцэтгэх болсонтой холбогдуулан ой бүхий газруудад 2023 оны 06 дугаар сарын 23-аас 2023 оны 08 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд хорио цээр тогтоосугай.

2. Хорио цээр тогтоосон ойн сан бүхий газарт гадаад дотоодын аялагч иргэд, мал оруулахгүй байхыг малчин, мал бүхий иргэд, аялагч нарт сурталчлан ажиллахыг Багийн Засаг дарга (Ж.Нямтогтох, С.Төмөр, Д.Бямбасүрэн, Д.Дэмиддагва, Г.Пүрэвтогтох, Г.Бямбагарав) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Байгаль хамгаалагч (Ж.Батмөнх, Б.Энхмаа), Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч (Х.Чулуунбат, М.Мөнхдалай, Ш.Баасансүрэн, Б.Цэдэнбал, Ц.Төмөрхуяг) нарт үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Н.ОРХОНТУУЛ

